



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/178

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Монголиан ойл консалтинг” ХХК-ийн ирүүлсэн хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/175 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь хэсэгт “Монголиан ойл консалтинг” ХХК (РД:6009123)-д эзэмшүүлсэн Мөрөн сумын 8 дугаар баг Ширэндэв-2 208 тоотод байршилтай 6712010638 нэгж талбарын дугаар бүхий үйлчилгээтэй орон сууцны зориулалттай 1925м<sup>2</sup> газрыг “Стресс сэвэрс” ХХК (РД:6306632)-д үлдсэн 16 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/175 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч хуулийн этгээд “Стресс сэвэрс” ХХК (РД:6306632)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712010566